



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/225

Номгон

Эзэмшил газрын зөрчил арилгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Иргэн Д.Батсүхийн худалдаа, үйлчилгээний зориулалттай 152.23 м2 газрын талбайн хэмжээ зөрүүтэй байгаа тул зөрчлийг арилган илүү эзэмшиж буй 113.77 м2 газрын үнийг төлүүлэн, нэмж эзэмшүүлж хавсралтаар баталсугай.

2.Газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн “Э” дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн Д.Батсүхэд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2011 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Газар эзэмших эрх олгох тухай” 155 дугаар захирамжийн хавсралтын 4 дэх хэсгийн иргэн Д.Батсүхийн талбайн хэмжээ хэсгийг хүчингүй болгосугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

1210563

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 29-ний
өдрийн А/225 дугаар захирамжийн хавсралт



ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ
ИРГЭНИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Хаяг	Талбайн хэмжээ /м2/	Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/	Нийт талбайн хэмжээ
1	Д.Батсүх	ВГ65010213	040700263- 001	Худалдаа нийтийн үйлчилгээни й газар, төв цогцолбор	Баянхонгор сум, Есөнбулаг 9-р баг, Эрхчөлөөний гудамж-4, 406 ТООТ	152.23 м2	113.77 м2	266 м2

оОо